



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 07 сарын 06 өдөр

Дугаар 352

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1, 5.6, 7.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын Дээд шүүхийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртөгөө бүрэн нөхсөн нийт 25,000,000.00 (хорин таван сая) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, үнийг 6,000,000.00 (зургаан сая) төгрөгөөр шинэчлэн тогтоож, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхэд балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Улсын дээд шүүхийн Тамгын газрын дарга Ж.Наранпүрэв, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн Тамгын газрын дарга Д.Одхүү нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх, бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Автомашины улсын дугаарыг шилжүүлсэн тодорхойлолт, арга хэмжээний биелэлтийг 2020 оны 3 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

000656



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 07 дугаар сарын 06 өдрийн
32 дугаар тогтоолын хавсралт

Улсын дээд шүүхийн тамгын газрын хөрөнгөд бүртгэлтэй
үнийг шинэчлэн тогтоож, балансаас балансад шилжих автомашин

Д/д	Автомашинны нэр, марк, бүртгэл, арлын дугаар	Үйлдвэрлэсэн /Ашиглалтад орсон он	Нийт гүйлт (км)	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Шинэчлэн тогтоосон үнэ /төгрөгөөр/	Ашиглах хугацаа /жилээр/
1	Суудлын Соната. Улсын дугаар 9564 УНУ арал КМНЕТ41СР8А434983	2008/2011	116,898	25,000,000.00	6,000,000.00	4
	Нийт дүн			/Хорин таван сая /	/зургаан сая/	